



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 10 сарын 06 өдөр

Дугаар А/295

Улаанбаатар хот

Хөрөнгө данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.6, 4.8 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2021 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 16,990,020 (арван зургаан сая есөн зуун ерэн мянга хорь) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан ном, сурах бичгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Баянзүрх дүүргийн 84 дүгээр сургууль (С.Марта)-т зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй нийт 16,990,020 (арван зургаан сая есөн зуун ерэн мянга хорь) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор зохих журмын дагуу устгалын акт үйлдэн устгахыг Баянзүрх дүүргийн 84 дүгээр сургууль (С.Марта)-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга (Б.Болор-Эрдэнэ)-д даалгасугай.

ДАРГА



М.БАЯРАА

115050000871

